



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 450

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн статистик мэдээллийн
талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.8 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалт, Статистикийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарын албан ёсны статистикийн мэдээ тайлан гаргах, мэдээлэх журмыг нэгдүгээрт халдварт өвчин, хамшинж, сэжигтэй тохиолдлыг бүртгэх, мэдээлэх журмыг хоёрдугаарт бэлгийн замаар дамжих халдварын тохиолдлыг бүртгэх, мэдээлэх журмыг гуравдугаарт сүрьеэ өвчнийг бүртгэх, мэдээлэх журмыг дөрөвдүгээрт хорт хавдрыг бүртгэх, мэдээлэх журмыг тавдугаарт эрүүл мэндийн бүртгэлийн болон тайлангийн маягтын жагсаалт хадгалах хугацааг зургаадугаарт шинэчлэн боловсруулсан анхан шатны бүртгэлийн болон тайлангийн маягтын загварыг долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Өвчний түүх бичих стандартыг 2014 оны эхний улиралд багтаан шинэчлэн боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулан, мөрдүүлэх ажлыг зохион байгуулахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар/ Я.Буянжаргал/-т даалгасугай.

3. 2014 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад Өвчний олон улсын 10 дугаар ангиллын 4 тэмдэглээт код, Үйлдлийн олон улсын 9 дүгээр ангиллыг нэвтрүүлэхийг зөвшөөрсүгэй.

4. Эрүүл мэндийн хөгжлийн төв/ Ч.Бат-Эрдэнэ/-д даалгах нь:
- 4.1. Бүртгэл, тайлангийн шинэчлэгдсэн маягтын загвар хөтлөх зааврыг шинэчлэн боловсруулж, хэвлүүлэх;
 - 4.2. Бүртгэлийн болон тайлангийн маяганд өөрчлөлт орсонтой холбогдуулан эрүүл мэндийн статистикийн програм хангамжийг шинэчлэх ажлыг тус тус 2014 оны 02 дугаар сарын 01-ний дотор багтаан зохион байгуулах.

002934

5. Бүртгэл, тайлангийн маягтуудыг хэвлүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусгах, өвчний түүхийг архивлах, хадгалах өрөөг орчин үеийн шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжөөр тоноглохыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын болон бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

6. Тушаалыг 2014 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөхийг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т даалгасугай.

7. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2010 оны 34 дүгээр тушаалыг хүчингүй болгосугай.

